



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 05 одор

Дугаар 9775

Мандалговь

Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн
байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.3.2, 10.4, 11 дүгээр зүйлийн 11.5, 32 дугаар зүйлийн 32.1.1, дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн хэмжээнд гамшигаас хамгаалах "Команд штаб" -ын дадлага сургууль зохион байгуулахтай холбогдуулан алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж, байгууллагуудыг 2019 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 09.00 цагаас 10-ны өдрийг дуустал хугацаанд гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

Хоёр. Аймгийн төв штабын байрыг төхөөрөмжлөх, шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж бэлэн байдалд оруулахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), гамшигийн зарлан мэдээллийн дохиог хүн амд шуурхай хүргэх, сурталчлах ажлыг зохион байгуулахыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ны албаны дарга (С.Түвшинжаргал), алба, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлэх, хүн хүч техник хэрэгслийг тодотгож бэлэн байдлыг хангуулахыг Онцгой байдлын газрын дарга, (дэд хурандаа М.Адъяабаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Команд штабын сургуулийн үед олон нийтийг хамарсан тэмцээн, уралдаан, соёл урлагийн арга хэмжээ, сургалт семинарын ажлаар явах, архи согтууруулах ундааны худалдаа үйлчилгээг зогсоох, хүндэтгэн үзэх шалтгаангүй нэгдсэн цугларалт, сургалт дадлагаас хоцорсон, тасалсан томилгоот бүрэлдэхүүнд болон алба хаагчдад хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), Сайнцагаан сумын Засаг дарга (Р.Мөнхтогтох) нарт хариуцуулсугай.

Дөрөв. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

488190471